



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

“Бүргэдийн баяр-2023” зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоол, “Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/93 дугаар захирамж, газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор “Бүргэдийн баяр-2023” арга хэмжээг “Чингис Хааны Хүрээ” аялал жуулчлалын цогцолборт 2023 оны 03 дугаар сарын 04,05-ны өдөр зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээг зохион байгуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 13,125,000 /арван гурван сая нэг зуун хорин таван мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.


4. Арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА *Д.Батсүх* Д.БАТСҮХ



1150500257

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 02 сарын 28 өдрийн
4/09 дүгээр тушаалийн нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
В.Батчимэг

Гишүүд:

Маркетинг сурталчилгаа хариуцсан
ахлах мэргэжилтэн С.Туул

Дотоодын аялал хариуцсан
мэргэжилтэн Т.Батдорж

Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан
мэргэжилтэн Б.Цолмонгэрэл

Нарийн бичгийн дарга:

Аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэлт
хариуцсан мэргэжилтэн
О.Одонтунгалаг

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 02 сарын 14 өдрийн
..... А/09 дугаар тушаалын хавсралт

**"БҮРГЭДИЙН БАЯР-2023" АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА**

2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Зохион байгуулалтын арга хэмжээ				
1	Баян-Өлгий-Улаанбаатар, Улаанбаатар-Баян-Өлгийн чиглэлийн автобусны зардал /хоёр талдаа/	20	260,000	5,200,000
2	Бүргэдчидийн хоол /хоёр талдаа/	20 4 удаа /өдөр, орой/	25,000	2,000,000
3	Зохион байгуулах ажлын хэсгийн хоол /2 өдөр/	13	25,000	325,000
Дүн				7,525,000
Сурталчилгаа, маркетингийн зардал				
4	Зар сурталчилгаа шторк, нэвтрүүлэг явуулах	Багц	2,000,000	2,000,000
5	Видео контент бэлтгэх, зураг авах	Багц	3,600,000	3,600,000
Дүн				5,600,000
Нийт дүн				13,125,000